



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/89

Булган сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2, 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Байнга дэлгэрэх" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн Сүрэнхорлоогийн Юмжавыг томилсугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21, 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.5, 28.2.6, 28.2.8-д заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээж оролцохыг итгэмжлэгдсэн төлөөлөгч (С.Юмжав)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА БАРИУН-ЭРДЭНЭ

